

∞ Мөнхөд... бас дараа нь ∞

Өмнөх хоёр нийтлэлд бид “мөнх” гэж орчуулдаг үгийн утгыг еврей ба грек Бичвэрүүдээс авч үзсэн. Энэ нь урт удаан үргэлжилсэн ч дуусах хугацааг заадаг үг болохыг бид олж харав.

“Мөнх” гэсэн үгийн утгыг мэдэх нь яагаад чухал вэ гэж үү?

Яагаад гэвэл энэ үгийн утга хүн бүрийн эдлэх “мөнхийн амьдрал” эсвэл “мөнхийн сүйрэл”-ийг тодорхойлж өгдөг. Христэд итгэгч бидний хувьд “мөнхийн амьдрал” ирээдүйн найдвар маань. Нөгөө талаар олон хүн, итгэгчид хүртэл, “там” гэж ойлгодог “мөнхийн шийтгэл”-ээс маш их айдастай явдаг. Энэ хувь заяа нь хэзээ ч дуусахгүйгээр үргэлжилнэ гэж бодохоос илүү аймшигтай зүйл үгүй. Гэтэл энэ ойлголт буруу болох нь тодорхой харагдаж эхэлж байна.



Нэгэнт “эон” гэсэн нэр үг төгсгөл бүхий урт хугацааг хэлдэг бол тус үгнээс гаралтай тэмдэг нэр болох “αἰώνιος” (“эоний”, мөнхийн) хэлзүйн дүрмээр нэр үгийнхээ утгаас хэтрээд дуусахгүй байдлыг заах боломжгүй нь ойлгомжтой.



“Мөнхийн” гэдэг нь тэгвэл “эон үед хамаатай”, “эон үед хамрагддаг”, “эон үед хамаарна”, “эон үеийн турш үргэлжлэх” гэх мэт утгатай болж таарна. Эсвэл монгол толь бичгийн дагуу “харьцангуй бат бэх орших чанар”-аар ойлгож болно.

Тэгсэн ч гэсэн теологичид “мөнхийн” гэснийг “ямар ч төгсгөлгүй” гээд эсрэг утгатай болгож тайлбарладаг. Энэ бол хэлний хууль дүрмийг зөрчсөн хэрэг. Улмаар, энэ сургаал нь итгэгчдийг даанч Ертөнцийн Эзэний Үг ба төлөвлөгөөг эрс буруугаар ойлгоход хүргэсэн.



Ертөнцийн
Эзэний
"мөнхийн
зорилго" бол
мөнхөд
үргэлжлэх
зорилго биш,

харин эоний үеүдэд товлосон зорилго болохыг бид мэдсэн (Эфэс 3:11). Үүнээс ч харахад "мөнхийн амьдрал" гэдэг нь ирээдүйн эоний үеүдэд хамаатай амьдралыг хэлнэ.

"Мөнхийн зовлон" гэсэн хэллэг Библийн эх хэлд бүр ч алга. Харин "эоний турш үргэлжлэх сүйрэл" эсвэл "эоний турш үргэлжлэх шийтгэл" гэж бий.



“Мөнхөд... бас дараа нь” гэж нэрлэсэн Их Эзэний төлөвлөгөө ямар төлөвлөгөө вэ? Тэрээр итгэгчдэд мөнхийн амьдралыг өгнө, гэвч итгэдэггүй хүмүүс мөнхийн сүйрэлд автах болохыг бид мэднэ. Гэтэл Ертөнцийн Эзэний төлөвлөгөөнд тэр мөнхийн амьдрал, мөнхийн шийтгэлийн дараа ч товлосон юм байна гэж үү? Байна!

1 Коринт 15:22-28-д энэ төлөвлөгөө товч танилцуулсан байна. Үүнд:

22 Адам дотор БҮГД үхдэгчлэн Христ дотор БҮГД амьд болгогдох болно.

23 Харин тус бүр өөрийн дараалалтай байна. Христ бол **анхны** үр жимс, **дараа нь** Түүнийг ирэхэд Христийнхэн амилуулагдана.

24 Дараа нь бүх удирдлага, эрх мэдэл, хүчийг Тэр хүчингүй болгоод, Эцэг Бурханд хаанчлалыг тушаах үед **төгсгөл** ирнэ.

25 Учир нь бүх дайснаа хөл дороо оруулах хүртэл Тэр хаанчлах ёстой.

26 Эцэст нь хүчингүй болох дайсан бол үхэл мөн.

27 "Бурхан бүх юмсыг Түүний хөл дор эрхшээлд нь оруулсан." Харин Тэр "Бүгд эрхшээлд орсон" гэж айлдах үед бүхнийг Түүний эрхшээл дор тавьсан Тэр Нэгэн нь [=Бурхан Эцэг] Өөрөө ангид байсан нь мэдээж.



28 Бүх юмс Өөрийнх нь [=Христийн] эрхшээлд орох үед Өөрт нь бүх юмсыг захируулагч Нэгэний [=Бурхан Эцэг] эрхшээлд Хүү Өөрөө ч мөн орох болно. **Энэ нь Бурхан бүгдэд бүх юм болохын тулд юм...** (АБ)



“Адам дотор БҮГД үхдэгчлэн Христ дотор БҮГД амьд болгогдох болно...”

Хүн бүр Адамаас болж нас бардаг шигээ эцэст нь Есүс Христээс болж амьд болгогдоно. “Амьд болгогдох” гэдэг нь хэзээ ч үхэшгүй амьтай

болохыг хэлнэ. Гэхдээ хүн бүр өөрийн гэсэн ээлжтэй. Нийт гурван ээлж бий. Эхнийх Есүс Их Эзэн Өөрөө. Түүнийг эргэж ирэхэд “өнөөгийн бузар булай эон үе” төгсөж (Галат 1:4) Түүнд итгэгч бидний “амь болгогдох” ээлж болно.



Ирээдүйн эон үеүдийн турш Есүс Их Эзэн бүх дайснуудаа дарах болно. Тухайлбал, ирэх эон үе мянган жилийн хаант улсыг хэлнэ. Тус хаант улсыг Петр “мөнх хаанчлал” буюу “эон үеийн турш үргэлжлэх хаант улс” гэж нэрлэдэг (2 Петр



1:11). Үүний дараа шинэ тэнгэр, шинэ дэлхийн эон үе болно (Илчлэлт 20:4-5; 21:1). Энэ бүх үеийн турш бид Түүнтэй хамт байх болно. Хүч чадал, цог жавхлан дүүрэн чухам энэ онцгой амьдралыг Библи “мөнхийн амьдрал” гэж нэрлэдэг. Дээр хэлсэнчлэн хамгийн сүүлчийн дайсан бол үхэл. Есүс үхлийг аль хэдийнэ ялсан боловч үхлийг үйлчлэхгүй болгох нь дутуу. Харин үхэл үгүй болох үед “мөнхийн шийтгэл”-ээр үхэлд баригдсан хүмүүсийн “амьд болгогдох ээлж” нь ирлээ. Тэгээд эон үеүдийн төгсгөлд Ертөнцийн Эзэн “бүгдийн дотор бүх юм нь” болж хамаг ертөнцийг Өөртэйгээ эвлэрүүлэх болно (Колоссай 1:20).

Үүний дараа юу болохыг Бичвэрүүд бидэнд хэлээгүй ч гэсэн үнэхээрийн гайхамшигтай бидний Эзэн үгээр хэлшгүй жавхлантай сайхан ирээдүйг бэлдсэн нь лавтай.

Гэхдээ “уучлагдашгүй гэм” гэж байдаг биш үү?

“Уучлагдашгүй гэм” гэсэн хэллэг Бичвэрүүдэд алга. Энэ хэллэгээр теологчид Есүсийн нэг үгийг “тодорхойлдог”. Үүнд: “Хүний Хүүгийн эсрэг үг хэлдэг хэн боловч уучлагдах болно. Харин Ариун Сүнсний эсрэг ярьдаг хэн ч энэ үед ч, ирэх үед





ч уучлагдахгүй.” (Матай 12:32). Ариун Сүнснийг эсэргүүцсэн хүн одоогийн эон үед ч, айсуй эон үед ч уучлагдахгүй нь үнэн.

Гэтэл Есүс тэрний дараах эон үеийн тухай юу ч хэлээгүй, эон үеүдийн төгсгөлийг бүр ч дурдаагүйг бид анхаарвал зохино.

“Уучлагдашгүй гэм” гэдэг бол Есүсийн үгийг тодорхойлох биш, харанхуйлах хэллэг учраас үгийн сангаасаа хассан нь дээр.


Мөнх зовлонт там тэгвэл ямар учиртай вэ?

Манай эриний эхний хэдэн зууны үед Христийн чуулганы удирдагчдын эх хэл нь грек байсан.

Тийм учраас «Шинэ Гэрээ»-ний сургаал ойлгоход саад болох хэлний бэрхшээл эртний чуулганд байгаагүй. Тэдний хэн нь ч тамын тухай заадаггүй байсан нь үнэхээр мэдүүштэй. Эртний Чуулганы хамгийн их хүндэтгэл хүлээсэн удирдагч бол багаасаа Христийг дагасан Александриа хотын Ориген (МЭ с.185 - с.253),

Антиох хотын Теодор (МЭ с. 350 – 428) хоёр байлаа.

Колоссай 1:20 зэрэг ишлэлд үндэслэн тэд





Ертөнцийн Эзэн бүх хүнийг Өөртэйгээ эвлэрүүлэх болно гэж заадаг байжээ. Теодор бол Дорнын Чуулганы “Несторийн” нэрэмжит урсгалын удирдагчдын нэг байлаа. Тус урсгалын итгэлийн тунхагт там хэзээ ч ороогүй, харин эсрэгээр нь “Есүс Их Эзэн ирээдүйд тэнгэрээс буун ирж, бид бүхнийг Өөртэйгээ нөхөрлөх нөхөрлөлд авч оруулна” гэж тунхагласан.¹

“Мөнхөд үргэлжлэх там”-ын тухай анх заасан “чуулганы эцэг”-ийн нэг бол Есүсийн үеэс 300 гаран жилийн дараа амьдарсан Өрнөд буюу Ромын Сүмд хамрагддаг Гиппо хотын Августин (МЭ 354-430). Алдарт Августин ихэд муу амьдралаар замнасан тэрээр 33 настайдаа христчин болсон. Тэгсэн ч гэсэн урьд нь сурч дээдэлдэг байсан “шинэ платонч” гэдэг грек гүн ухааныг хаяагүй, харин ч Бичвэрүүдийн сургаалтай нийлүүлэхээр зүтгэдэг байв. Тамын тухай сургаалыг барьж “Чуулганы удирдлагатай итгэлийн талаар санаа нийлэхгүй хүмүүсийг Чуулган хавчих ёстой” гэж мөн заадаг болжээ.

1 Несторийн урсгалынхан хэдхэн зууны дотор Энэтхэг, Хятад ба 6-р зуунд манай Монголд хүртэл хүрсэн. Чингис хааны үед олон монгол итгэгч байдаг байжээ. Үүнээс харахад “Есүс бүх хүмүүсийг аварна” гэдэгт итгэх нь Түүний тухай бусдад ярьж, илгээлтийн ажил хийхэд саад болохгүй. Улмаар, мөнхийн зовлонт тамын айдсаар хүмүүсийг айлгахгүйгээр авралын зар тараах ажил явагдах нь бүрэн боломжтой.



Августин латин хэлтэй болохоос грек хэл мэдэхгүй бөгөөд грек хэлзүйг үзэн яддагаа бичиж үлдээсэн. Гэсэн хэдий ч Католик Сүм түүнийг өнөө хүртэл “Сүмийн теологийн доктор” ба “гэгээнтэн” гэж өргөмжилдөг. Католик Сүмийн теологид ба Христитгэлд Августин шиг асар их нөлөө үзүүлсэн өөр чуулганы эцэг байхгүй.

Энэ нөлөө ялангуяа тамын тухай өнөөгийн Христитгэлийн сургаалаас харагддаг. Тамын

тухай онол сургаалаа Августин ялангуяа Матай 25:46 дээр үндэслэсэн. Үүнд: “Тэд мөнх шийтгэлд, харин зөвт нь мөнх аминд орох юм...”

Августины тайлбараар “эон гэдэг үг нь зөвт хүмүүсийн хүртэх амийг ч, муу хүмүүсийн авах шийтгэлийг ч тодорхойлдог учраас нэг л хугацааг хэлнэ. Хэрэв “мөнх шийтгэл” нь хэсэг хугацааны дараа дуусах юм бол “мөнх амьдрал” ч гэсэн тэр хугацааны дараа төгснө гэсэн үг. Энэ ишлэлд яригдаж буй мөнхийн амьдрал хэзээ ч дуусахгүй нь тодорхой учраас мөнхийн шийтгэл мөн адил дуусах боломжгүй” гэж маргажээ.



Олон хүний хувьд энэ тайлбар нь тамын дуусашгүй чанарыг хангалттай баталдаг. Ямартай ч олон теологич тамын оршин байдгийг батлах гэж яг энэ адилхан маргааныг ашигладаг.

Гэтэл өөрийнх нь хүлээн зөвшөөрснөөр грек хэл мэддэггүй хүнээс бид грек үгийн утгыг сурах ёстой гэж үү? “Эон” гэдэг үг тодорхой цаг хугацааг заадгийг бид нэгэнт мэдээд Ертөнцийн Эзэний эон үеүдэд товлосон төлөвлөгөөг гадарладаг болсон учраас Августины маргаанд хариулж чадна. Тухайлбал:

1-рт "Зөвт хүмүүсийн хүртэх эон үеүдийн турш үргэлжлэх амь ч, муу хүмүүсийн авах эон үеүдийн турш үргэлжлэх шийтгэл ч тодорхой хугацаатай, аль аль нь төгснө" гэхэд Августины зөв.

Гэтэл 2-рт "эон үеүдийн турш үргэлжлэх мөнхийн амьдрал дуусах ёсгүй" гэхэд Августин тус амьдралыг үхэшгүй амьдралаас ялгаж ойлгодоггүй учраас буруу дүгнэлтэд хүрчээ. Эон үеүд дуусахад үхэшгүй амь хүртэж амжаагүй хүмүүс ч төгсөшгүй амийг хүртэх болно. Тэгсэн цагт Ертөнцийн Эзэн бүгдийн дотор бүх юм нь болно (1 Коринт 15:22-28).

Тэртэй тэргүй, үхэшгүй амьтай болох найдвар маань Августины барьсан ишлэлээс, бас “эон” гэдэг үгийн утгаас шалтгаалахгүй, харин

ертөнцийн Аврагч болох Есүс Христ дээр тогтдог. “Үхэгсэд үл муудахаар амилуулагдана”, “зөвт хүн итгэлээр амьдарна”, “бид Эзэнтэй үргэлж хамт байх болно” зэрэг Ертөнцийн Эзэний бидэнд өгсөн тов тодорхой амлалтанд бид итгэж, Ер бусын Аавынхаа хувиршгүй хайр, хязгааргүй их хүч чадалд найдвараа тавьдаг учраас хэзээ ч дуусашгүй, мөнхөд бас дараа нь үргэлжлэх амьдралтай болохыг хүлээдэг (Ром 1:17; 1 Коринт 15:52; 1 Тесалоник 4:17).²

Бас санах ёстой маш чухал зүйл бол энэ: **Библийн аливаа ишлэлийг бид зөв ойлгохын тулд заавал хам сэдвээр нь уншиж, хам сэдвээр нь ойлгох ёстой.** “Хам сэдэв ноёрхоно” гэдэг (англиар: “Context is King”). Тийм учраас Матай 25:46-г дангаар нь биш, дор хаяж Матай 25:31-46 хүртэлх хэсэгт хамаатуулж унших ёстой. Тэгвэл энэ ишлэл



2 “Мөнхөд үргэлжлэх байдал” гэсэн утгатай үг «Шинэ Гэрээ»-нд байхгүй ч тэр чанарыг агуулсан үг бий. Тухайлбал, “үл муудагч”, “мөхөшгүй байдал”, “алга болчихгүй”, “гандашгүй”, “үхэшгүй” г.м. Ирээдүйд бидний хүлээж авах ер бусын амьдрал чухам тийм чанартай юм (Ром 1:23; 2:7; 1 Коринф 9:25; 15:42, 51-54; Еврей 7:15-16; 1 Пэтр 1:3-4; 5:4; 1 Тимот 1:17; 6:16; 2 Тимот 1:10).

сайн, муу хувь хүмүүсийн тухай биш, харин “зөвт”, “зөвт бус” үндэстнүүдийн тухай болохыг олж харна. “Есүст итгэдэг үндэстэн” гэж энэ дэлхийд байхгүйг бид мэдэх учраас үндэстний зөвт байдал нь Есүст итгэх итгэлээр хэмжигдэхгүй нь ойлгомжтой.

Харин Есүсийн “ах дүүс” болох израйльчуудад ирж айсуй буй хүнд хэцүү зовлонтой үед нь тусалсан үндэстэн бүр зөвтөд тооцогдон ерөөгдөх болно. Тэдэнд туслаагүй үндэстэн тэр шүүлтэнд хараагдана.

Энэ бол Ертөнцийн Эзэний анх Абрахамд өгсөн амлалтын дагуу: “Чамайг ерөөгчдийг Би ерөөж, Чамайг хараагч нэгнийг би хараана...” (Эхлэл 12:3). □

Дараагийн нийтлэлд “мөнх амь” ба “мөнх шийтгэл”-ийн тухай Бичвэрүүдийн сургаалыг дэлгэрэнгүй авч үзнэ.

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Г. Баяржаргал (2016.05.02): “Монголчуудын христитгэл хийгээд Библийн монгол орчуулгын түүхэн тойм”, Теологийн Товхимол, 67-р х. Retrieved Oct 15, 2023 from

[https://www.academia.edu/30822058/ Монголчуудын Христитгэл хийгээд Библийн монгол орчуулгын түүхэн тойм Brief History of Christianity in Mongolia and Bible Translation in Mongolian in Mongolian](https://www.academia.edu/30822058/Монголчуудын_Христитгэл_хийгээд_Библийн_монгол_орчуулгын_түүхэн_тойм_Brief_History_of_Christianity_in_Mongolia_and_Bible_Translation_in_Mongolian_in_Mongolian)

---Hanson, J.W. (1899). Universalim: The prevailing doctrine of the Christian Church during its first five hundred years (and showing the influence of Greek mythology and pagan philosophy on Christian doctrine). Boston and Chicago: Universalist publishing house. Retrieved July 20, 2019 from <https://tentmaker.org/books/Prevailing.html#271>

---Jones, S.E. (2019). The Meaning of Eternal and Everlasting. Retrieved from <https://www.gods-kingdom-ministries.net/teachings/articles-and-poetry/the-meaning-of-eternal-and-everlasting/>

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org